

ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЦЭРГИЙН ХЭЭРИЙН ХҮНСНИЙ ХАНГАМЖИД ХИЙСЭН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Б.Наранбаатар

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, хошууч

Товч агуулга: Гадаадын зарим улсын цэргийн хээрийн хүнсний хангамжийн өнөөгийн байдлыг судлан хил хамгаалах байгууллагад нэвтрүүлэх боломжийн талаар дүгнэлт, санал дэвшүүлэхэд оршино.

Abstract: Some foreign military field food supplies the possibility of introducing the current situation info the border protection organization to make conclusions and suggestions.

Түлхүүр үгс: Цэргийн хээрийн хүнсний хангамж, АНУ, БНХАУ, МУ, харьцуулсан судалгаа, ХХБ нэвтрүүлэх боломж

Keywords: Military field food supply⁸ USA, China, MU, comparative stude, TDF adoption

Оршил: Цэргийн хээрийн хүнсний хангамж нь аливаа улсын цэргийн алба хаагчид тусгай болон хээрийн ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, бэлтгэн явуулах, түүний үр дүнд нөлөөлөхүйц чухал ач холбогдолтой юм.

Иймд дэлхийн чиг хандлага хэрхэн өрнөж байгаа түүгээр зогсохгүй үр дүнд хэрхэн нөлөөлөх зэргийг тусгах болно. Гадаадын зарим улсын цэргийн хээрийн хүнсний хангамж тэр дундаа цэргийн ажиллагааны хоногийн өгцийг судалснаар Хил хамгаалах байгууллагад нэвтрүүлэх боломж нэмэгдэх юм.

Нэг. Цэргийн хээрийн хүнсний хангамж, төрөл, үүрэг зориулалт

1.Цэргийн хээрийн хүнсний хангамжийн тухай ойлголт

Цэрэг нь тухайн улсын армид хамаарах галт зэвсгээр зэвсэглэсэн явган цэргээс армийн генерал хүртэлх гишүүдийг хэлнэ.¹

Хүнсний хангамж нь амьд организм бий болсноос хойш байгалийн хуулийн дагуу ямар нэгэн байдлаар амьдрахын тулд олон төрлийн хоол хүнсийг ашиглаж ирсэн.

Монгол Улсын “Хүнсний тухай” хуульд “Хүнс” гэж хүний бие махбодын хэвийн үйл ажиллагааг хангах, эрүүл мэндийг дэмжин хамгаалахад шаардагдах хүнсний түүхий эд, хагас болон бүрэн боловсруулсан бүтээгдэхүүн, ундны усыг хүнс гэж нэрлэнэ гэж тусгасан байна.²

Олон улсад хүнсний хэрэглээг “Хүн бүхэн эрүүл, идэвхтэй амьдрахын тулд хангалттай шим тэжээлийн хувьд бие махбодын хэрэгцээнд тохирсон, аюулгүй, соёл, ёс заншилд нийцсэн хоолоор хангагдах”-ыг хэлнэ гэсэн байна. (FAO.Right to Food and Nutrition, 1972) “Дэлхий ертөнц дээр амьдарч буй бүхий л хүмүүс амьдралынхаа туршид эрүүл, тэжээлтэй хоол хүнс хэрэглэх эрхтэй” (Дэлхийн хүнсний дээд хэмжээний уулзалт, 1996) гэж заасан байна

¹ Википедиа толь 2004 он

² “Хүнсний тухай хууль” төрийн мэдээлэл 2023 оны 01 дүгээр тойм

1.2. Хоол хүнсний үүрэг, бүрэлдэхүүн:

Хүнс, хоол нь хүний бие махбодын эд, эсийг бүтээгч олон зуун нэгдлээс бүрдэх бөгөөд тэдгээр нь бие махбодод илч үүсгэж, физиологийн хэвийн үйл ажиллагааг хангах, эд, эсийг нөхөн сэргээх үүрэг гүйцэтгэдэг.

Хүнс, хоолны үндсэн үүрэг

- Хүний бие махбодын энергийн үндсэн эх үүсвэр

- Шинэ эд эсийн үндсэн материал

- Бодисын солилцоог зохицуулах биологийн идэвхт нэгдлийн эх үүсвэр

Эд, эсийн нөхөн төлжилтөд шаардлагатай уураг, тос, нүүрс-ус, аминдэм, эрдэс зэрэг нь хоол, хүнсээр дамжин бие махбодод шингэнэ. Түүнчлэн хүнс нь фермент, даавар болон бодисын солилцоонд шаардлагатай зохицуулах үйлчилгээтэй нэгдлийн эх үүсвэр болно. Бодисын солилцоог дэмжих, зохицуулах үйлчилгээтэй 100 гаруй нэгдэл байдгийн тал хувь нь хүний биед нийлэгжихгүй тул зайлшгүй хүнс, хоолоор авах шаардлагатай. Хүний биед зайлшгүй шаардлагатай, чандмань эрдэнэ-усны үндсэн эх үүсвэр нь хүнс юм. Хүний биед 60 орчим шимт бодис, үүнээс 18 төрлийн аминхүчил, 12 аминдэм, 16 эрдэс бодис зайлшгүй шаардлагатай юм. Өдөр бүр хоол, хүнснээс авах уураг, тос, нүүрс-усны харьцаа 1:1.3:4.6 байвал хамгийн тохиромжтой хэмээн мэргэжилтнүүд үздэг.

Хүн агаарын хүчилтөрөгчгүйгээр 3 минут, усгүйгээр 3 хоног, хоол хүнсгүйгээр 30 хоног л амьдрах чадвартай. Хүнс нь “Зөв хэрэглэвэл эм, буруу хэрэглэвэл хор” болдог¹ “асар том зэвсэг” юм. Учир нь хүний бие махбод хоол, хүнс дэх бодисоос бүтдэг. Өнөө үед хүнсний хэрэглээний чиг хандлага эрс өөрчлөгдөж, хүн эрүүл мэндээ дээдлэн байгалийн цэвэр бүтээгдэхүүн

хэрэглэх, биологийн идэвхт нэгдэл агуулсан хоол хүнс хэрэглэхийг эрхэмлэх болжээ. Хүний биед хэрэгцээтэй биологийн идэвхт бодис агуулах хүнсийг экологийн хувьд цэвэр түүхий эдээр бэлтгэснээр эрүүл мэндэд тустай хүнс хэрэглэх боломж бүрдэнэ.

Хоол, хүнс нь тухайн үндэстний онцлог шинж чанарын илэрхийлэл болох бөгөөд түүний хангамж, аюулгүй байдлын үзүүлэлтээр улс гүрний хөгжин дэвших эсвэл доройтон буурч буйг тандан ажиглах боломжтой. Аливаа улс гүрний төрийн бодлогын цөм нь хүн ардынхаа эрүүл мэнд, амь насыг хамгаалахад чиглэж байдаг. Нийгэм хөгжин тэлэхийн хирээр хүний сэтгэл зүй, амьдралын орчин болон хөдөлмөр эрхлэлтийн салбарт гүнзгий өөрчлөлт үргэлжлэн гарч байна. Үүнээс физик-химийн болон биологийн гаралтай хорт бодисоор цаг тутам бохирдож буй ус, агаар, хөрс; хүн амын огцом өсөлттэй урвуу хамааралтайгаар хомсдох хүнсний түүхий эдийн нөөц, хөдөлмөр эрхлэлттэй зохицохгүй хүнсний хэрэглээ, химийн гаралтай хүнсний нэмэлтүүдийг түгээмэл ашиглах болсон зэрэг олон өөрчлөлтийг нэрлэж болох юм. Хүн ба хүнсийг тойрсон эдгээр өөрчлөлт хувьслууд нь хүний биед үүсэх олон эмгэгийн суурь шалтгаан болж байна. Тухайлбал соёл иргэншлийн хэмээх тодотголтой хэт таргалалт, хавдар, чихрийн шижин, судас хатууралт, ясны сийрэгжилт, зүрх-судасны, хоол боловсруулах болон мэдрэлийн тогтолцооны өвчнүүдийг нэрлэж болно. Иймээс хүн ардыг чанаргүй хоол, хүнснээс хамгаалах зайлшгүй шаардлага гарч байна.

Цэргийн хээрийн хүнсийг зориулалтаар нь Хувь хүний-Группийн-Амьд үлдэх хоол гэж ангилах ба дотор нь Тэргүүн шугамынх, Шашны, Цаг агаарын,

¹ “Хүнсний хангамж аюулгүй байдал, хоол тэжээл” үндэсний хөтөлбөр 2001 он

Сургалтын, Нисэх хүчний, Усан цэргийн, Газарзүйн байрлалын гэж ангилдаг.

Судлаач миний эрдэм шинжилгээний бүтээлд Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хүнсний хангамжийн хэрэглээг бүсчилсэн байдлаар тодорхойлж, хилийн эрлийн үед хуурай хүнсийг олон улсын жишгээр хангахад чиглэж байгаа юм.

Хоёр.Гадаадын зарим улсын цэргийн албан хаагчдын хүнсний

хангамж, хоногийн өгцөд хийсэн судалгаа

Гадаадын зарим улсад цэргийн алба хаагчийн хоногийн аяны хүнс (хүн нэг бүрийн хуурай)-ний бүтцийг тусгайлан тогтоож багцлан Зэвсэгт хүчиндээ нийлүүлж байна.Үүнд:

2.1.Оросын Холбооны улсын цэргийн хээрийн хүнсний хангамж ОХУ-д 29 нэр төрлийн өтгөрүүлсэн болон шахмал бүтээгдэхүүн агуулсан, өглөө, өдөр, оройн хоолны 7 нэрийн хоол, зуушнаас бүрдүүлж гаргаж байна

Хүснэгт 1. ОХУ-ын тусгай хүчний аяны хүнсний нор

№	Бүтээгдэхүүний нэр	Х.н	Хоногт бүгд	Бүтээгдэхүүний хуваарилалт		
				Өглөөний хоол	Өдрийн хоол	Оройн хоол
1	Нэгдүгээр зэргийн Улаан буудайн талх	гр	100	50		50
2	Шигшсэн гурилан талх	гр	100		100	
3	Татаж бөөрөнхийлсөн үхрийн мах	гр	250		250	
4	Давсалсан гахайн мах	гр	100			100
5	Нухаш	гр	50	50		
6	Хиам	гр	50			50
7	Үхрийн мах, гурвалжин будаатай хуурга	гр	250	250		
8	Төмстэй гуляш	гр	250			250
9	Ястай мах, ногооны зууш	гр	100		100	5
10	Жимсний бэлдмэл	гр	75	25	25	25
11	Ариутгасан хайлмал бяслаг	гр	80			80
12	Жимсний чанамал	гр	45	45		
13	Жимс, жимсгэний	гр	100			100
14	Гашуун шоколад	гр	30	30	5	
15	Байхуу цай	ш	4		2	2
16	Найруулдаг кофе	ш	2	2		
17	Хуурай зөөхий (хуурай сүү)	ш	2	2		
18	Элсэн чихэр	ш	60	20	20	20
19	Давс	таб	5			
20	Перец	ш	1			

21	Амин дэм	ш	1			
22	Бохь	ш	10			
23	Ус ариутгагч бэлдмэл	ш	3	1	1	1
24	Халаагч хэрэгсэл	ш	1			1
25	Ус салхинд тогтвортой чүдэнз	ш	6			
26	Гарын ариутгасан цаас	ш	3	1	1	1
27	Цаасан алчуур	ш	3	1	1	1
28.	Хуванцар халбага	ш	3	1	1	1
29.	Хуванцар хутга	ш	1	1		

2.2.Америкийн Нэгдсэн Улсын цэргийн хээрийн хүнсний хангамж

АНУ-ын Зэвсэгт хүчинд нэг цэргийн алба хаагчийн нэг хоногийн аяны хүнс нь хадгалах хугацаа урттай (1-7 жил), цаг агаарын ямар ч нөхцөлд хадгалах боломжтой, химийн халаагууртай, 24 нэр төрлийн үндсэн хоолны цэстэй, 3900- 4000 ккал илчлэгтэй байдаг.

НҮБ-ын цэргийн хангалтад нийлүүлдэг цэргийн алба хаагчийн аяны хүнсний иж бүрдэл (СКР2 vombat ration racket) нь дотроо өдрийн хоол, оройн хоол, нэмэгдэл хүнс, нэмэгдэл хэрэгсэл бүхий А, В, С, D, E, К гэх мэт 11 төрөл байх ба төрөл тус бүр нь дотроо цэсийн сонголтой байна.

Тэргүүн шугамын хуурай хүнс нь 9 төрөлтэй ба шарсан талх, сэндвич, шоколад, самрын тос, үхрийн мах,

жимс, сүү, бохь, ундаа /ус/ салфетик, халбага, сэрээ, халаагч багтдаг.

Шашны хоол нь шашны онцлогийг харгалзан 2 төрөл байдаг ба 1200 ккал илчлэгтэй, 10 сарын хадгалах хугацаатай хүйтэн болон халуунаар идэхэд зориулагдсан

Сургалтын хоол нь 12 төрөл байдаг ба 18 сарын хадгалах хугацаатай хээрийн сургуулилт, сургаалтанд хамрагдаж байгаа цэргүүдэд зориулагдсан

Группийн хүнсийг нийтэд нь тараадаг ба 50 хүнийг 3 өдрийн хоолны илчлэг нь 3400 ккал 18 сар хадгалах хугацаатай байдаг. Хүнсний хангамжийн бүтэц нь дараах боловсруулсан хоолноос бүрдэж байна.

Хүснэгт 2. НАТО-гийн цэргийн хуурай хүнс

д/д	Бүтээгдэхүүний нэр	Х.н	Хоногт бүгд	Тайлбар
1	Ногоотой шөл	гр	300	үүнээс 75 гр мах
2	Вандуйтай ногоотой шөл	гр	300	үүнээс 75 гр мах
3	Цэлцгэнүүр	сав	2	тус бүр 10 гр
4	Хатаасан кекс	боодол	2	тус бүр 125 гр
5	Элсэн чихэр	уут	2	тус бүр 12.5 гр

6	Жимсний чанамал	сав	1	45гр
7	Маргарин	сав	1	25гр
8	Давс	уут	1	3гр
9	Кофе	уут	2	тус бүр 3,5 гр
10	Хуурай сүү	уут	2	тус бүр 3 гр
11	Жимсний хатаасан сироп	уут	1	30 гр
12	Бохь	боодол	1	14 гр
13	Ус ариутгагч эм	таблеток	8	
14	Ариутгалтай амны алчуур	боодол	1	
15	Ариун цэврийн цаас	ш	4	25х20 см
16	Чүдэнз	ш	20	
17	Гялгар уут	ш	2	30х40см
Хоолны нийт жин нь		гр	1200	
Хоолны илчлэг нь		ккал.	3058	

2.3.Бүгд найрамдах Хятад ард улсын хүнсний хангамж

БНХАУ-д цэргийн хүнсний хээрийн норм буюу нэг цэргийн алба хаагчийн аяны хүнсэнд даршилсан махтай гоймонг байгалийн гаралтай будаа, гоймонг боловсруулж жимс, хүнсний ногоо, амтлагч, мөн амны

цангааг хурдан тайлах үйлчилгээтэй хатуу ундаа мэт дагалдах бүтээгдэхүүний хамт зөөлөн саванд савлаж хийсэн байна.

Хятадын цэрэгт 09 загварын 12 төрлийн өөрөө халдаг ба хоол нэг бүр нь бүтэцтэй байдаг.

Хүснэгт 3. БНХАУ-д цэргийн хүнсний хээрийн норм

д/д	Хоолны нэр	Бүтээгдэхүүний нэр	Х.н	Тоо	Хоногт бүгд	Тайлбар
1	Хоол №1 Шар буурцагтай будаатай хуурга	хадгалалт даах нарийн боов	гр	60	300 гр	
		үхрийн махан өндөгтэй ороомог	гр	40		
		чихэрлэг хан боргоцой	гр	55		
		амталсан жан	гр	15		
		хурдан хайлдаг ундаа	гр	10		
2	Хоол №2 Холимог будаатай хуурга	хадгалалт даах хайрсан бин	гр	60	300 гр	
		жантай үхрийн мах	гр	40		
		чихэрлэг хан боргоцой	гр	55		
		амталсан жан	гр	15		
		хурдан хайлдаг ундаа	гр	10		
3	Хоол №3 Тахианы махтай	хадгалалт даах нарийн боов	гр	60	300 гр	

	хуурга	үхрийн махан шөл	гр	40		
		чихэрлэг шар тоор	гр	55		
		амталсан жан	гр	15		
		хурдан хайлдаг ундаа	гр	10		
4	Хоол №4 Хавтгай буурцагтай, үхрийн махтай хуурга	хадгалалт даах хайрсан бин	гр	60	300 гр	
		үхрийн махан өндөгтэй ороомог	гр	40		
		чихэрлэг хан боргоцой	гр	55		
		амталсан жан	гр	15		
		хурдан хайлдаг ундаа	гр	10		
5	Хоол №5 Жантай хуурга	хадгалалт даах хайрсан бин	гр	60	300 гр	
		үхрийн махан	гр	40		
		чихэрлэг шар тоор	гр	55		
		амталсан жан	гр	15		
		хурдан хайлдаг ундаа	гр	10		
6	Хоол №6 Галитай хуурга	хадгалалт даах хайрсан боов	гр	60	300 гр	
		үхрийн махан шөл	гр	40		
		чихэрлэг хан боргоцой	гр	55		
		амталсан жан	гр	15		
		хурдан хайлдаг ундаа	гр	10		
7	Хоол №7 Хиамтай хуурга (бордсон гэдэс)	хадгалалт даах хайрсан боов	гр	60	300 гр	
		Жантай үхрийн мах	гр	40		
		чихэрлэг хан боргоцой	гр	55		
		амталсан жан	гр	15		
		хурдан хайлдаг ундаа	гр	10		
8	Хоол №8 Нарийн ногоо махтай хуурга	хадгалалт даах хайрсан бин	гр	60	300 гр	
		үхрийн махан	гр	40		
		чихэрлэг шар тоор	гр	55		
		амталсан жан	гр	15		
		хурдан хайлдаг ундаа	гр	10		
9	Хоол №9 Нарийн ногоотой махтай хуурсан гоймонтой хуурга	хадгалалт даах хайрсан боов	гр	60	300 гр	
		Үхрийн махтай шинэ гэдэс	гр	40		
		чихэрлэг хан боргоцой	гр	55		
		амталсан жан	гр	15		
		хурдан хайлдаг ундаа	гр	10		
10	Хоол №10 Шинэ мөөг махтай хуурсан гоймонтой хуурга	хадгалалт даах хайрсан бин	гр	60	300 гр	
		үхрийн махан өндөгтэй ороомог	гр	40		
		чихэрлэг шар тоор	гр	55		
		амталсан жан	гр	15		
		хурдан хайлдаг ундаа	гр	10		

11	Хоол №11 Хонины махтай хулуутай хуурга	хадгалалт даах нарийн боов	гр	60	300 гр	
		Жантай үхрийн мах	гр	40		
		чихэрлэг хан боргоцой	гр	55		
		амталсан жан	гр	15		
		хурдан хайлдаг ундаа	гр	10		

**3.Хүнсний хангамжийн
өнөөгийн байдал**

3.1.Түүхэн дараалал, хөгжлийн
үе шат

Хил хамгаалах байгууллага үүсэж байгуулагдсан эхний жилүүдэд /1933-1950-иад онд/ түүний хөгжлийн оргил үед /1977-1990 онд/ ч амжилт, бүтээл, алдаа оноо аль аль нь байжээ. Хүнсний хангамж нь олон хүчин зүйлээс хамааралтайгаас гадна отряд, застав, хилчин нэг бүрд хүрч байж үр дүн нь тодорхой болдог онцлогтой юм.

Хил хамгаалах байгууллагын хангалт үйлчилгээний түүхийг эргэн харахад улс орны нийгмийн хөгжлийн онцлогтой уялдан үе үеийн шинж чанарыг агуулсан байна. Тухайлбал:

Хил хамгаалах байгууллагын ар тал, техникийн хангалтын алба үүсэж хөгжсөн үе /1933-1944 он/

Хилийн цэрэг байгуулагдсан үеэс түүний хүнсний хангамж хариуцсан төрөл мэргэжлийн албад байгуулагдаж эхэлжээ. Монгол Улс хил хамгаалалтын ар тал, техникийн хангалт үйлчилгээг үүсгэж хөгжүүлэхдээ ЗХУ-ын мэргэжилтнүүдийн онол, практикийн асар их тусламжийн үр дүнд үндэслэсэн.

Дайны үеийн ар тал, техникийн хангалт /1944-1951 он/

Дайны цагт улсын хилийн хамгаалалтыг зохион байгуулж явуулах түүний хангалт үйлчилгээг Монгол улсын төрөөс анхаарч төрийн бодлого болгон хэрэгжүүлсэн. Хүнсний хангамжийг төвөөс застав, фронт

хүртэл цувраажилтаар хангагдаж байсан бөгөөд их хэмжээний материал, ялангуяа галт хэрэгсэл, шатахуун зарцуулагдаж байсан тул Зөвлөлтийн армийн туршлагаар хэмжих нэгжийг байлдааны үеийн тооцоо хангалтын нэгжээр тооцох эхлэл гарч байсан байна.

Хүйтэн дайны үеийн ар тал, техникийн хангалт /1967-1990 он/

Дэлхийн II дайны төгсгөлөөс бий болсон социалист капиталист системийн зөрчил өрсөлдөөн болон өрнөд, умард хоёр хөршийн таагүй харьцаа Монгол оронд нөлөөлж улсын хилийн хамгаалалт түүний хангалт үйлчилгээнд онцлог байдал үүссэн. Болзошгүй дайнд бэлтгэж их хэмжээний хүнсний хангамжийн нөөц хуримтлуулсан.

3.2.Өнөөгийн байдал:

Хүнсний алба нь хилийн отряд /анги/-ыг мэргэжлийн удирдлагаар ханган хүнсний материалын хангалтын тооцоо, зах зээл дэх үнийн судалгааг хийж, Орон нутаг-Төвлөрсөн-Хосолсон аргаар хангалтыг 100 хувь бэлтгэн зохион байгуулж байна.

Хил хамгаалалтын хэлбэрүүдэд зохион байгуулах хүнсний хангамжийн нөөцүүдийг албаны бэлэн байдлын удирдамжид зааснаар бүрдүүлэн зааврын дагуу сэлгэлт хийж албанд ашиглаж байна.

Эдийн засгийн хязгаарлагдмал боломжид бие дааж хангалтыг зохион байгуулах шаардлагатай болсон зэрэг онцлогийг бодит баримтаар тусгасан байна.

Дөрөв.Гадаадын зарим улсад хэрэглэж буй хүнсний хангамж /хоногийн өгц/-ийг хил хамгаалах байгууллагд нэвтрүүлэх боломж

4.1.Хүнсний хангамжийн талаар

Дэлхийд цэрэг армийн бүрэлдэхүүний хооллолт, эрүүл аюулгүй хоол хүнсээр хангагдах нь улс орны аюулгүй байдалтай шууд холбоотой гэж хэлж болох ба өөрсдийн хөгжил, эдийн засгийн байдал, шашин шүтлэг, цаг уур температурын өөрчлөлт, цэргүүдийн бие физиологийн үйл ажиллагаа, энерги зарцуулалтын үйл ажиллагаанаас хамааран шинэ аюулгүй хүнсээр хангаж ажиллахын тулд олон шинжилгээ судалгаанд багагүй хөрөнгө мөнгө зарцуулсаар байна.

Үүний нэг хэсэг нь цэргийн хүнсэнд бэлэн боловсруулсан бүтээгдэхүүнээр хангах явдал юм.

Иймд гадаадын зарим улс цэргийн хүнсний хангамжаа хэрхэн зохион байгуулдаг, манай улсад тохирох хүнсний бүтээгдэхүүн, технологийг судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна

Хүнсний бэлэн бүтээгдэхүүнээр хүн нэг бүрийг хангах нь Хил хамгаалах байгууллагын хувьд хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хил

зөрчигчийг эрж саатуулах, хилийн эрэл зохион байгуулахад болон байгаль, цаг уурын өөрчлөлт, хүн малын гоц халдвар, хилийн манаа, бүлгүүдийг хилд томилон үүрэг гүйцэтгүүлэх үед тэдгээрийн хүнсний хангамжийг бүс нутгийн байгаль, цаг уур, хилийн цагийн байдал, хилчдийн өвчлөлийн байдалтай уялдуулан зохион байгуулах нь зүйтэй юм гэдэг хил залгаа улсууд болон бусад оронд явуулж байгаа туршлагаас харагдаж байна.

Монгол улсын Зэвсэгт хүчинд Монгол улсын засгийн газрын “Хүнсний хангамжийн хэмжээг тогтоох тухай” 2006 оны 103 дугаар тогтоолын 4, 5, 6 дугаар баганад Тусгай үүрэг гүйцэтгэх цэргийн албан хаагчийн хүнс, КШС, Хээрийн сургууль, Гамшиг, ослын үед хэрэглэх хуурай хүнс,Олон улсын энхийг сахиулах ажиллагаа хамтарсан сургууль дадлагад оролцох бие бүрэлдэхүүний хүнс гэж ангилан баталгаажуулсан байна.¹

4.2. Хил хамгаалах байгууллагад нэвтрүүлэх боломжийн талаар


Хилчдийн дунд энергийн зарцуулалтыг гадаадын зарим улсын цэргийн хээрийн хүнсний илчлэгтэй харьцуулсан байдал

¹ “ХХБ ар тал, техникийн хангалтын эрх зүйн баримт бичгийн эмхтгэл” Г.Ганбаатар /2006 он/


Зураг 1.¹

Бүсүүд	Энерги зарцуулалт	ОХУ	Таарах эсэх	БНХАУ	Таарах эсэх	АНУ	Таарах эсэх
Уулархаг бүс	4505.8	4585,6	+	4500,6	-	3950,4	-
Говийн бүс	4199.0		+		+		-
Ой тайгын бүс	4196..5		+		+		-
Тал хээрийн бүс	3874.7		+		+		+
Төвийн бүс	4090.3		+		+		-

Зураг 2.²



Зураг 3.



Зураг 4.



¹ “Монгол улсын хилчдийн энерги зарцуулалт” Я.Нямдорж Д.Ганбаатар /2003 он/

² “Хоолны газрын нийтлэг журам” хууль / 2002 оны 5 дугаар сарын 17-ны өдөр /

Манай улсын хүнсний үйлдвэрүүд болох “Хатан сүйх”, “Хүн – од” зэрэг компаниуд цэргийн хээрийн хүн нэг бүрийн хүнсийг туршилтаар үйлдвэрлүүлж ОХУ, БНХАУ, АНУ-ын цэргийн хээрийн хүнсний хадгалах хугацаатай дүйцэхүйц хүнсний бэлэн боловсруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхээр ажиллаж байна. Үүнд:

Зураг 5. “Хүн од” ХК-ний санал болгож буй хүн нэг бүрийн хоногийн өгц

Бүтээгдэхүүний нэр		Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Уураг	Өөх тос	Нүүрс ус	Илчлэг калорь
1	Цагаан будаатай хуурга /240гр/	1	6500	17.08	36.5	97.9	797
2	Махан консерв /240 гр/	1	9800	52.32	22.5		531.1
3	Ногоотой махан консерв /240гр/	1	5945	14.16	51.7	34.4	662.9
4	Гурвалжин будаатай хуурга /240 гр/	1	5780	22.8	91.3	37.5	1064
5	Элэгний нухаш /90 гр/	1	5600	8.7	25.4		278.2
6	Жигнэмэг	3	2400	23.6	1.5	144.5	716
7	Шоколад /70%-тай/ /ш/	1	1600	2.2	19	27.8	299
8	Кофе /нэг удаагийн/ /ш/	2	400	3	0.7	1.4	3.8
9	Паркеттай цай /ш/	3	1100				
10	Халбага /ш/	1	120				
11	Сэрээ /ш/	1	120				
12	Салфетка /ш/	1	440				
13	Халаах суурь, хуурай спиртэн түлш /тулгатай/ /ш/	1	4300				
Нийт		18	44105 /төгрөг /	143,8	249	343,4	4352

Дүгнэлт,

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд өргөн хэрэглээний хүнсний хангамж нь 25 нэр төрлийн хуурай хүнсээр хангагдаж, хагас боловсруулан

бүлгүүдийн хангалтыг зохион байгуулж байна.¹

Дээрх судалгаанаас харахад ОХУ-ын тусгай хүчний цэргийн хээрийн хүнсний иж бүрдэл Хил хамгаалах байгууллагын цэргийн албан

¹ ХХЕГ-ын даргын а/22 дугаар тушаал “Хүнсний хангалтын заавар”

хаагчдын хоногт зарцуулдаг энергийг хангаж байгаа нь харагдаж байна. БНХАУ-ын цэргийн хээрийн хүнсний илчлэг уулархаг бүсэд хүрэлцэхгүй бусад бүсэд хэрэглэхэд тохиромжтой, АНУ-ын цэргийн хээрийн хүнс тал хээрийн бүсэд л хүрэлцэхүйц байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Хүнсний хангамжийн хүн нэг бүрийн хоногийн өгц ашиглах нь авч явахад хялбар бөгөөд хоол боловсруулах цаг хугацаа, хүн хүч, тоног хэрэгсэл болон тээвэрлэлтээс үүсэх цэргийн нууцлал, өнгөлөн далдлалт алдагдах зэрэг арга хэмжээнд эергээр нөлөөлөх давуу талтай байгаа нь практикт ажиглагдаж байна.

Санал

Хүнсний хангамжийн нөөцийн зохих хувийг хоногийн хуурай өгц хэлбэрээр нөөцлөх;/тусгай томилгоот бүлэг, олон хоногоор үүрэг гүйцэтгэдэг бүрэлдэхүүнийг тухайн бүсийн онцлогт тохирсон хүн нэг бүрийн хоног өгцөөр хангадаг болгох. Энэ нь байгаль цаг уурын онцлог, цаг агаарын огцом өөрчлөлтөд ТТБ төөрөх, осгох, эмнэлгийн тусламж бүх төрлийн хангалт үйлчилгээ авахад хүндрэлтэй, байгалийн гэнэтийн үзэгдэл болох үед нөөц хүнсийг ашиглах,

Хүнсний хангамжийн зарим бүтээгдэхүүний удаан хугацааны

хадгалалтыг шинжлэх ухаан технологийн хөгжлийн ололтыг ашиглан уртасгах боломжийг нэмэгдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрийг бий болгох, одоо байгаа үйлдвэрийг дэмжих; олон хоногоор хилийн манаанд үүрэг гүйцэтгэдэг бүсийн онцлогт тохирсон хангамжийг бий болгох Тухайлбал: Вакум орчинд савласан бүтээгдэхүүн, хатаасан бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүн.

Энэ хүнсний хангамжийн ашиглалтын хугацааг нэгдсэн хангалт хийх бүрд сольж шинэчлэх байх хэрэгтэй цаашид энэ нь судалгааны томоохон ажил болох байх гэдэг бат итгэлтэй байна.

Эх сурвалжийн жагсаалт:

1. “Органик хүнсний тухай” хууль /2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн шинэчилсэн найруулга/
2. Б.Лхагва 2003 он “Хилийн цэргийн ар талын хангалт үйлчилгээ олон талтай”
3. Д.Ганбаатар 2005 он “Хилийн заставын материал техникийн хангалт”
4. Б.Лхагва 1989 он “Цэргийн аж ахуйн зарим асуудал”
5. Хилийн цэргийн аж ахуйн сурах бичиг
6. Б.Лхагва 2005 “Хилийн цэргийн ар талын хангалтын зарим асуудал”